



**ТУУЛ ГОЛЫН ЭРЭГ ДАГУУХ ТОХИЖИЛТЫН АЖИЛ (22 ДУГААР ХОРОО)-ЫН  
ЗУРГИЙН ДААЛГАВАР**

2023 оны 12 дугаар сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

1.	Төсөл боловсруулах үндэслэл	<ul style="list-style-type: none"> <li>- Нийслэлийн Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 26 дугаар тогтоол.</li> <li>- Хот байгуулалт хөгжлийн газрын 2023 оны МЗХ2023/00-133 дугаартай тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар.</li> </ul>
2.	Байршил, эдэлбэр газрын хэмжээ	<ul style="list-style-type: none"> <li>- Хан-Уул дүүргийн 22 дугаар хороо Туул голын эрэг дагуу.</li> </ul>
3.	Зориулалт, хүчин чадал	<ul style="list-style-type: none"> <li>- Иргэд амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх цэцэрлэгт хүрээлэн.</li> </ul>
4.	Төсөл гүйцэтгэх хугацаа	<ul style="list-style-type: none"> <li>- Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.</li> </ul>
5.	Төсөл боловсруулах үе шат	<ul style="list-style-type: none"> <li>- Талбайн судалгаа, хэмжилт хийх. (Ажлын тоо хэмжээг захиалагч байгууллагатай зөвшилцэн батлуулах)</li> <li>- Инженер геологийн судалгаа, дүгнэлт гаргуулах.</li> <li>- Захиалагч болон мэргэжлийн байгууллагуудтай зөвшилцэх.</li> <li>- Загвар зураг болон ажлын зураг төсөв боловсруулж батлуулах. (2 үе шаттай талбайн угсралтын ажлыг хийж гүйцэтгэхээр зураг төсөл боловсруулах)</li> <li>- Төсөвт өртөг (магадлал хийгдсэн байх).</li> <li>- Батлагдсан зураг төсвийн дагуу ажил гүйцэтгэх.</li> </ul>
6.	Төсөл боловсруулах байгууллага	<ul style="list-style-type: none"> <li>- Барилга хот байгуулалтын Яамны сайдын тушаалаар батлагдсан ЗТ-8.1 Орчны ерөнхий төлөвлөгөө, тохижилт, өндөжилтийн ажлын зураг төсөл боловсруулах эрх бүхий байгууллага, аж ахуйн нэгжүүд оролцох боломжтой.</li> </ul>
7.	Төслийн захиалагч	<ul style="list-style-type: none"> <li>- Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар.</li> </ul>
8.	Орон зайн төлөвлөлтэд тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> <li>- Архитектур орон зайн төлөвлөлтийг тус байршилын онцлог, шаардлага, орц гарц. Орчны ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулж тохижилтын шийдэл гаргаж төлөвлөх.</li> </ul> <p><b>Ногоон байгууламж:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Одоо байгаа мод, бут, сөөгийг гэмтээхгүй шинээр Монгол орны уур амьсгалд тохирсон шилмүүст болон навчит мод, бут, сөөг, зүлэг тарьж ногоон байгууламжийг нэмэгдүүлэх.</li> <li>- Ногоон байгууламжийг хамгаалсан хайс төлөвлөх. (модон шонтой)</li> </ul> <p><b>Тоглоомын талбай:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хүүхдийн нас насны ангилалд тохирсон, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, орчин үеийн загвар хийцлэлтэй цогцолбор тоглоом төлөвлөх.</li> <li>- Тоглоомын талбайн стандарт болон норм, норматив MNS ISO8124-1:2011, MNS ISO8124-2:2011, MNS ISO8124-3:2011, MNS ISO8124-4:2011 мөрдөх.</li> <li>- 3x3 сагсан бөмбөгийн талбай төлөвлөх.</li> </ul> <p><b>Амралтын талбай</b></p>

	<ul style="list-style-type: none"> <li>- Гэр бүлээрээ амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх орчин үеийн загвар шийдэл бүхий тохижилттой талбай төлөвлөх.</li> </ul> <p><b><u>Спорт талбай:</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Спортын 3-5 төрлийн талбайг төлөвлөх.</li> </ul> <p><b><u>Явган хүний зам, ундадаг дугуйн зам талбай:</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Зорчигчдын амрах талбай болон хүний хөдөлгөөнийг салгаж зорчигчдын хөдөлгөөнийг сайжруулах орц гарцыг нэмэгдүүлж төлөвлөх.</li> <li>- Явган хүн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар MNS 6056:2009 стандарт.</li> <li>- Явган замыг өвлийн улиралд халтиридаггүй гадаргуутай хавтангаар төлөвлөж, тайлбарт тусгах.</li> <li>- Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавигдах ерөнхий шаардлага UCS0901B мөрдөх.</li> <li>- Унадаг дугуйн замын төлөвлөлт, хучилтад тавигдах шаардлага ерөнхий шаардлага UCS0903B мөрдөх.</li> </ul> <p><b><u>Авто зогсоол:</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Авто замын явах хэсэг, тээврийн хэрэгслийн зогсоол, тэмдэг тэмдэглэгээг стандартын дагуу төлөвлөх.</li> <li>- Авто зогсоолын /БНБД 21-5-10/, автомашины ангилал, ерөнхий шаардлага, Монгол улсын стандарт "MNS:5342:2003"-д нийцүүлж төлөвлөх.</li> </ul> <p><b><u>Бусад:</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Ариун цэврийн байгууламж, сандал, сүүдрэвч, хогийн сав гэх мэт тохижилтын бусад элементийг төлөвлөх.</li> <li>- <b>Үерийн хамгаалалтын далан шуудуу төлөвлөх.</b></li> </ul>
9.	<p>Инженерийн дэд бүтцэд тавигдах шаардлага</p> <ul style="list-style-type: none"> <li>- Эрчим хүчинд хэмнэлттэй дэвшилтэй технологийн шийдэл бүхий орчин үеийн загвар хийцлэлтэй гэрэлтүүлэг төлөвлөх.</li> <li>- Үерийн ус зайлзуулах шийдлийг орчны байгууламжуудтай уялдуулан нэгдсэн байдлаар иж бүрэн шийдвэрлэх.</li> </ul>
10.	<p>Төсөл боловоруулжад ашиглах материалы</p> <p><b><u>Хууль тогтоомжууд:</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Газрын тухай хууль</li> <li>- Барилгын тухай хууль</li> <li>- Усны тухай хууль</li> <li>- Хот байгуулалтын тухай хууль</li> <li>- Эрчим хүчин тухай хууль</li> <li>- Хог хаягдлын тухай хууль</li> <li>- Бусад хуулиуд</li> </ul> <p><b><u>Норм, нормативууд:</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Барилгын инженер геологийн ажил /БНБД 11-03-01/</li> <li>- Барилгын геодезийн ажил /БНБД 11-08-06/</li> <li>- Барилга захиалагчийн дүрэм</li> <li>- Барилгын бүтээц ба сүүрийн найдваршил. Ерөнхий шаардлага /БНБД 20-01-11/</li> <li>- Ачаалал ба үйлчлэл /БНБД 20-04-17/</li> <li>- Газар хөдлөлийн бус нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм /БНБД 22-01-01*/</li> <li>- Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт /БНБД 23-01-09/</li> <li>- Барилгын төсөв зохион дүрэм /БНБД 81-95-12/</li> <li>- Цахилгаан техникийн ажил /БНБД 3.05.06-90/;</li> <li>- Бусад холбогдох норм, дүрэм</li> </ul> <p><b><u>Стандартууд:</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>- "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага" MNS 4990:2000</li> <li>- "Ажлын байрны бичиг цаг уурын эрүүл ахуйн хэмжээ" MNS 12.013-91</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>- "Ажлын байрны хүчдэлийн түвшин" MNS 12.097-91, MNS 12.098-91, MNS 12.101-091</li> <li>- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөтөч зам, налуу шатыг шийдэх /MNS 6056:2003, 6055:2009/;</li> <li>- Иж бүрэн гудамж: Хашаа, хайс, хашлагад тавигдах ерөнхий шаардлага, хэрэглээ /UCS0001-02:2019/</li> <li>- Иж бүрэн гудамж: Тээврийн хэрэгслийн ил зогсоолыг төлөвлөх, байгуулахад тавигдах ерөнхий шаардлага /UCS0902B:2020/</li> <li>- Бусад холбогдох стандартууд</li> </ul>
11.	Эдийн засгийн тооцоо, төсөв	<ul style="list-style-type: none"> <li>- Эдийн засгийн тооцоо болон төсвийг БНБД 81-95-12 болон эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн программаар тооцох.</li> </ul>
12.	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> <li>- Тохижилтын стандарт мөрдөн төлөвлөх.</li> <li>- Хотын стандартын удирдамж, арга зүйн баримт бичиг мөрдөх.</li> </ul>

ХЯНАСАН:

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Л.ОТГОНБАЯР

БОЛОВСРУУЛСАН:

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИЯДЛАГЫН ХЭЛТСИЙН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

О.МӨНГӨНШАГАЙ

**ТОХИЖИЛТЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ДААЛГАВАР**

2023 оны 09 сарын 27 өдөр

Дугаар:МЗХ2023/00-133

Улаанбаатар хот

1	Төсөл боловсруулах үндэслэл	<ul style="list-style-type: none"> <li>- Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 75 дугаар тушаалаар баталсан "Нийтийн эдэлбэрийн газрыг дахин төлөвлөн байгуулах үйл ажиллагааны журам",</li> <li>- "2022 оныг Хотын иргэний жил болгон зарлах тухай" Нийслэлийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 03-ний өдрийн А/01 дүгээр захирамж,</li> <li>- Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 03/1485 дугаартай албан бичиг.</li> </ul>
2	Тохижилтын ажлын нэр /терел/ байршил	<p style="text-align: center;">Туул гол дагуух эргийн тохижилт; Хан уул дүүргийн 22 дугаар хороо,</p>
3	Тохижилт хийх газрын хэмжээ /Зориулалт/	<p style="text-align: center;">50204.4 м<sup>2</sup> /Нийтийн эдэлбэр газарт/</p>
4	Төслийн захиалагч	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
5	Төсөл гүйцэтгэх хугацаа	Захиалагч гүйцэтгэгч талуудын байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.
6	Төсөл боловсруулах үе шат	<p>Төслийг хоёр үе шаттай боловсруулна.            -Судалгаа, загвар зураг (2 хувь А4, А3 хэмжээтэй, CD)            -Ажлын зураг</p>
7	Төлөвлөлтийн орон зайд тавигдах шаардлага	<p>-Архитектур орон зайн төлөвлөлтийг Нийслэл хотын онцлог, шаардлага, орц гарц, орчны батлагдсан ерөнхий төлөвлөгөө, төсөл хөтөлбөр, тохижилтын төлөвлөлтийн шийдлэлтэй уялдуулан, холбогдох хууль, норм ба дүрмийг мөрдлөг болгох.  <b>Явган зам талбай:</b>            - Хот байгуулалтын тухай хууль 12.6.1. /гудамж, замын сүлжээг тээврийн хэрэгсэл, дугуйтай ба явган зорчигчийн хөдөлгөөн, нутаг дэвсгэрийн зохион байгуулалт, орон зайн зохиомж, орчны барилга байгууламжийн байршил, уран барилгатай нь уялдуулан, тасралтгүй есэн хөгжих хөдөлгөөнтэй нэгдсэн систем байх/-ийг мөрдөх.            -"Явган хүн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар" MNS6056:2009-стандарт, "Тахир дутуу хүнд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль" /БД 31-101-04/, "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн шаардлага хангасан зураг төсөл зохиох заавар" /БД 31-112-11/ норм стандартын шаардлага хангасан замын орон орон зайдай байна.            -Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавигдах шаардлага (UCS 0901B:2022)-д нийцүүлэн төлөвлөх.  <b>Хүүхдийн тоглоомын талбай:</b>            Хүүхдийн тоглоомын талбайг төлөвлөхөд тавих ерөнхий шаардлага /UCS 1405B:2022/-д нийцүүлэн төлөвлөх.  <b>Унадаг дугуйн зогсоол:</b>            -Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилт /БНБД 30-01-04/-ийг баримтлан Унадаг дугуйн замыг төлөвлөхөд тавих ерөнхий шаардлага /MNS 5683:2016/ болон унадаг дугуйн замын төлөвлөлт, хучилтад тавигдах шаардлага /UCS 0903B:2022/-д нийцүүлэн төлөвлөх.  <b>Авто зам, зогсоол:</b>            -Авто зам, зогсоолыг барьж байгуулахдаа Нийслэлийн Замын хөгжлийн газартай зөвшлилцөх.            -Тээврийн хэрэгслийн ил зогсоолыг төлөвлөхдөө тухайн орчмын ерөнхий төлөвлөлтийн уялдуулан Тээврийн хэрэгслийн ил зогсоолыг төлөвлөх, байгуулахад тавигдах ерөнхий шаардлага /UCS 0902B:2022/-д нийцүүлэн төлөвлөх.</p>

НИЙСЛЭЛИЙН  
ХӨГЖЛИЙН  
ЗААНЫ  
ХАРГААЛЫН  
АРХИТЕКТОРЫН  
ТӨЛӨВЛӨЛТИЙН  
ДААЛГАВАР

ЕРӨНХИЙ АРХИТЕКТОРЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН  
ДААЛГАВАР

2023 оны 09 сарын 27 өдөр

Дугаар: МЗХ2023/00-133

		<p><b>Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоол:</b> Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолд тавих өрөнхий шаардлага /UCS 1601B/-д нийцүүлэн төлөвлөх.</p> <p><b>Ногоон байгууламж:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>-Ногоон байгууламж болон зүлэгжүүлэн тохицуулах талбай, зурvas байршил хэмжээ, нутаг дэвсгэрийн онцлог нехцэл, үйт ажиллагааны чиглэл зориулалтад тохируулан тогтоох.</li> <li>-Төлөвлөлтийг хийдээ Хот суурин газрын цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн төлөвлөлтийн шаардлага /UCS 0801A:2022/-д нийцүүлэх.</li> <li>-Байгалийн ландшафтын онцлог ба экологийн систем түүний аюулгүй байдал, тэнцвэртэй байдлыг хадгалан хамгаалах, сэргээх, арчлах, шаардлагатай тохиолдолд хуучин байсан ургамал, мод сеөг зэргийг өөр байршилд шилжүүлэхийг зөвшөөрөх.</li> <li>-Мод, сеөг, ургамлын төрөл зүйлийн сонголтыг Мод, таримал ургамлын төрөл зүйлийн лавлах /UCS 0803B:2022/-ийг судлан байршиж буй бус нутгийн ур амьсгалын нехцэл, цэцэрлэгжүүлэлтийн зориулалт, нар, салхины нөлөөлөл, агаарын бохирдолт, хөрсний нехцэл ургамлан нөмрөгийн байдалд тохируулж, тадгээрийн өнгө, титмийн холборийг оновчтой онгон төлөвлөх.</li> </ul> <p><b>Хашаа хайс:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>-Нийслэлийн нутаг дэвсгэрт хашаа, хайс, барих, ашиглах, буулгах журмыг баримтлах.</li> <li>-Хашаа, хайс, хашлагад тавигдах өрөнхий шаардлага, хэрэглээ / UCS 1410B:2022/-д нийцсэн байх.</li> <li>- Хашааны өнгө, загвар, өндөр зэргийг дээрх стандартын дагуу төлөвлөж загвар зурагт гудамжны дэлгээс зургаар харуулах</li> </ul> <p><b>Гэрэл, гэрэлтүүлэг:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>-Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг /БНБД 23-02-08/, Гэрэлтүүлэг чимэглэлийн ажлын хөдөлмөр зарцуулалтын жишиг /БНБД 83-27-00/ баримтлан Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд байршуулах гэрэлтүүлгийн тоног төхөөрөмжид тавигдах шаардлага /UCS 1901B:2022/-д нийцүүлэн төлөвлөх.</li> <li>-Гэрэлтүүлэг нь аюулгүй орчныг бурдуулэх, оновчтой байршилтай, эдийн засгийн үр ашигтай, эрчим хүчиний хэмнэлттэй, нарны эрчим хүчийг ашигласан эко байхаар төлөвлөх.</li> <li>-Мэргэжлийн хяналтаар баталгаажсан олон улсын шаардлагад нийцсэн дизайн загвар нь орчны тохижилтод нийцсэн сайн чанарын гэрэл төлөвлөх.</li> <li>-Тохижилтгын талбайг гэрэлтүүлэх хангамжийн бие даасан сэргээгдэх эрчим хүчиний эх үүсвэрээс хангагдах хэсгийн мэдээлэл, эх үүсвэрийн хүчин чадал, ачаалал зэргийг тооцож төлөвлөх.</li> </ul> <p><b>Сандал:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>-Нийтийн гудамж зам талбайд байршуулах сандалд тавигдах шаардлого /UCS 1404B:2022/-д нийцүүлэн төлөвлөх.</li> </ul> <p><b>Саравч, сүүдрэвч:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>-Саравч, сүүдрэвчид тавигдах өрөнхий шаардлага / UCS 1402B:2022/-д нийцүүлэн төлөвлөх.</li> </ul> <p><b>Хогийн сав:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>-Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд байршуулах хогийн саванд тавигдах шаардлага / UCS 1403B:2022/-д нийцүүлэн төлөвлөх.</li> </ul> <p><b>Бусад:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>-Мэргэжлийн хяналтаар баталгаажсан сайн чанарын тоног төхөөрөмж тавьж, Олон улсын стандартад нийцсэн хэмжээтэй төлөвлөх.</li> <li>-Хяналтын камер, тамхины цэг, хүний анхан шатны хэрэгцээ болох цэвэр ус уух цорго төлөвлөх.</li> </ul> <ul style="list-style-type: none"> <li>- Эдэлбэр газарт газрын зураглалын тодруулалт хийлгэх, газар доорх болон дээрх шугам сүлжээг тодруулсны үндсэн дээр зураг төслийг боловсруулах, инженерийн шугам сүлжээний засвар, арчлалтын арга хэмжээтэй уялдсан төлөвлөлтийн шийдлийг сонгох</li> <li>- Гадаргуугийн ус залуулах арга хэмжээг орчны байгууламжуудтай нэгдсэн байдлаар иж бурэн шийдвэрлэх</li> </ul>
8	Инженерийн дэд бүтцэд тавигдах шаардлага	

		<b>Зургийн иж бүрдэл:</b> Зурган мэдээлэл, судалгаа, - Одоогийн байдал, судалгааны танилцуулга - Байршилын схем M1:10000 - Орчны тойм M1:5000 - Байрзүйн дэвсгэр зураг M1:500 - Одоогийн байгаа явган зам, талбай, автозамын сүлжээ M1:1000 - Одоогийн ногоон байгууламжийн байгуулалт /Дендрологийн байгуулалт/ <b>Төлөвлөлтийн зураг</b> - Нуур худас /Батлагдах худас/ - Төлөвлөлтийн танилцуулга /Архитекторын шийдэл/ - Гудамж замын сүлжээ M1:1000 - Ерөнхий төлөвлөгөө M1:1000 /Батлагдах худас/ - Хөдөлгөөний схем M1:2000 - Явган зам, авто зам талбайн байгуулалт - Гэрэлтүүлгийн байгуулалт - Харагдах байдал /Төлөвлөлтийн орчинд эвлүүлсэн зураглал/ - Дендрологийн байгуулалт - Дендрологийн шилжүүлсэн байгуулалт - Өндөржилт M1:1000 - Улаан шугам M1:5003 - Ус зайлзуулах сувгийн зураг M1:1000 - Инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурvas M1:1000 - Хог, хаягдалын төвлөрүүлж, тээвэрлэх, зөөверлөх цэгийн схем M1:2000 <b>Зураг төсөлд стандарт масштабыг хэрэглэнэ.</b> - Явган хүний замыг төлөвлөхдөө үргэлжилсэн хөдөлгөөнийг ямарч саадгүй зорчих нехцлийг бүрдүүлэх. - Тухайн цэцэрлэгжилтэнд Монгол орны уур амьсгалд тохирсон шилмүүст мод, навчит мод, бут сеөг, зулгэ тарих. - Төлөвлөлтөд саад болж буй одоо байгаа мод, бут сеөгний үндэсийг гэмтээхгүйгээр ногоон байгууламжийг нэмэгдүүлэх. - Зураг төслийн болон ажил гүйцэтгэх явцад тухайн нутаг дэвсгэрийн инженерийн шугам сүлжээний хариуцах байгууллагатай болон холбогдох газруудтай зөвшилцэх. - Явган хүний замын хүчилтүүг одоо байгаа авто замын хашлагын ёндөртэй нэг түвшинд хийх. - Борооны ус болон үерийн хамгаалалтын бэлтгэл арга хэмжээ авах. Амьд ургамалын хайсыг ногоон байгууламжийн хамгаалалт гоёл чимэглэлд хэрэглэх бөгөөд амрах хэсэгтэй уялдуулах. - Гудамжны зорчих хөдөлгөөний орц, гарцыг судалж оновчтой байшилаар тапааялах - Хотын энгэ үзэмжийг нэмэгдүүлэх шинэлэг загвар дизайн бухий тохижилтын элементуудийг төлөвлөх. - Тохижилтүүм элементийг сонгоходоо үерийн усанд тэсвэртэй хийц материалыг сонгон авах. - Сэлбэ тул гол дагуух унадаг дугуйн замын төслүүдтэй уялдуулах. Голын онцгой болон энгийн бусийн дагламжийг баримтлах - Төслийг боловсруулахдаа эзэмшил газар, төлөвлөгдсөн авто зам байгаа эсэхийг тухайн хариуцсан байгууллагуудаас авч хамтран ажиллах. - Зураг төслийн болон ажил гүйцэтгэх явцад тухайн нутаг дэвсгэрийн инженерийн шугам сүлжээний хариуцах байгууллагатай болон газар эзэмшиг холбогдох газруудтай зөвшилцэх. <b>Голын онцгой болон энгийн бусийн дэглэмийг баримтлах</b>
9	Төслийн иж бүрдэл	
10	Онцгой нөхцөл	
11	Захиалагчийн нэр, утас	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар, С.Энхбаяр; Утас: 77771965

**Анхааруулга:**

1. Монгол Улсын хуулиуд; Хот байгуулалтын тухай хууль; Барилгын тухай хууль, Газрын тухай хууль, Усны тухай хууль, Бусад холбогдох хуулиуд, бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрүүд, УИХ-ын 2013 оны 2-р сарын 08-ний 23 дугаар тогтооюур батлагдсан "Улаанбаатар хотын 2020 оны ерөнхий

2013 оны 09 рокорын 27-дээр

ГРАФИК № 2317401

төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага"-ын баримт бичиг, Бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрүүд, Норм, дүрэм, Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНБД 30-01-04/, Хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах аргачилсан заавар /УББ 11-202-00/, Барилгын орчны тохижилтын ажил /БНБД 3.01.06-90/, Бусад холбогдох норм, дүрмүүдийг баримтална.

2. Зураг төслийг хот байгуулалтын мэдээллийн санд хүлээж авахад тавигдах шаардлага:
  - Хот байгуулалтын мэдээллийн сангийн стандартыг мөрдөх.
  - Хийгдэж буй төслийн дэвсгэр зургийг UTM48N /WGS84/ буюу солбицлын нэгдсэн тогтолцоонд хийж гүйцэтгэх.
  - Загвар зургийн эх сурвалж /AutoCAD, 3D MAX, Sketchup, Lumion/-ийн файлыг хүлээлгэн өгөх. Мен material, texture хавсаргах.
3. Тохижилтын зураг төслийг боловсруулахдаа даалгаварт заасан нэр, зориулалт, хэмжээнээс хэтрүүлсэн тохиолдолд загвар зураг батлагдахгүй болно.
4. UCS 0801A, UCS 0803B, UCS 0901B, UCS 0903B, UCS 1405B, UCS 1406B, UCS 1407B, UCS 1704A, UCS 1901B, UCS 1902A - Улаанбаатар хотын Стандартын баримт бичгүүдийг мөрдөх.

ХЯНАСАН

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН  
ХОТ ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА.

  
С.ДАЛАНЖАРГАЛ


БОЛОВСРУУЛСАН  
ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН  
ХОТ БАЙГУУЛАЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



# ТОХИЖИЛТЫН АЖЛЫН СХЕМ ЗУРАГ

МЗХ2023/00-133 дугаартай Тохиижилтийн ажлын төлөвлөлтийн даалгаврын хавсралт

Байршил	Эзэмшигч	Зориулалт
Хан-Уул дүүргийн 22 дугаар хороо	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар	Туул гол дагуух эргийн тохиижилт



105° 54' 00" E

Масштаб 1:5000

Тусгаг: EPSG:\$[projcs]

## ТОДОРХОЙЛОЛТ

(Архитектур төлөвлөлтийн даалгаврын хамт хүчинтэй.)

## ЭРГЭЛТИЙН ЦЭГҮҮДИЙН СОЛБИЦОЛ

№	X	Y	тал=урт(м)
1	641737.278	5305334.625	1-2=87.017
2	641818.911	5305304.493	2-3=22.339
3	641809.085	5305284.431	3-4=100.803
4	641899.724	5305240.320	4-5=43.156
5	641900.220	5305283.473	5-6=217.409
6	642099.916	5305369.427	6-7=155.488
7	642085.666	5305524.261	7-8=165.618
8	641929.460	5305469.224	8-9=222.828
9	641740.834	5305350.597	9-1=16.363

## ТАНИХ ТЭМДЭГ

- Одоо байгаа барилга  
Төлөвлөлтийн хэргэвэрүүн хэмжээ
- Газрын хэмжээ
- Цэээр усны шуваг
- Бодогын шуваг
- Дулганы шуваг
- Хамбооны шуваг
- Урийн шуваг

1 Төлөвлөх буй байршил
2 Дунжинзаарын гудамж
3 Одоо байгаа ширеэн зам
4 Туул гол
5 Одоо байгаа барилга

## ОЛГОСОН ТАЛБАЙН ТОДОРХОЙЛОЛТ

Эдэлбэр газар м <sup>2</sup>	-
ТОХИЖИЛТЫН ТАЛБАЙ м <sup>2</sup>	-56204.4



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг  
**ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР**  
Хот төлөвлөлтийн халтас

Хан-Уул дүүргэ, 23-р хороо, Арцатын ам /17100/  
Навадамчдын зэм 1200  
Цахим хуудас: [www.udz.ub.gov.mn](http://www.udz.ub.gov.mn), [www.ebarilda.ub.gov.mn](http://www.ebarilda.ub.gov.mn)  
Утас: 11-324975